

Өмнөх үг

“Эдийн засаг: онол, практик” сэтгүүлийн анхны дугаар бараг хориод жилийн өмнө, 2000 онд хэвлэгдэн гарсан билээ. Тухайн үед улс оронд маань төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих шилжилт ид явагдаж, нийгэм эдийн засгийн хүрээнд шинэчлэлт өөрчлөлтүүд эрчимтэй хийгдэж байсан. Эдгээрийн нэг нь боловсролын салбар, тэр дундаа дээд боловсролын салбар дахь өөрчлөн байгуулалт байсан юм. Тухайлбал, их, дээд сургуулиудын эдийн засаг, бизнесийн салбарын сургалтын хөтөлбөрийг Европын өндөр хөгжилтэй орнуудын сургалтын хөтөлбөртэй ойртуулан шинэчлэх, бакалавр, магистрын шаталсан сургалтыг бий болгож, кредит системийн эхлэлийг тавих шаардлага тулгарсан билээ. Энэ нь зөвхөн хөтөлбөрийг өөрчлөн шинэчилснээр шийдэгдэх асуудал биш, харин багшлах боловсон хүчнийг бэлтгэх, чанаржуулах, өргөн цар хүрээтэй ажлаас эхлэх учиртай байсан. Ийм ч учраас багш нарынхаа сургалт, судалгааны ажлыг дэмжиж, судалгааны ажлынх нь үр дүнг хэвлэн нийтлэх, олны хүртээл болгох, шүүн хэлэлцүүлэх боломж олгох зорилгын үүднээс энэхүү сэтгүүлийг анх санаачлан гаргаж эхэлсэн юм.

Сэтгүүлийг анх МУИС-ийн Эдийн засгийн сургууль, “Эдийн засгийн боловсрол холбоо” төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж, хэвлүүлдэг байсан билээ. МУИС дахь бүтцийн өөрчлөлтийн явцад Эдийн засгийн сургууль татан буугдаж, сэтгүүл маань ч хэсэг хугацаанд тасалдахад хүрсэн юм. Энэ дугаараас эхлэн сэтгүүлийн үйл ажиллагааг МУИС-ийн Эдийн засгийн тэнхим үргэлжлүүлж, уншигч болон судлаачдын хамрах хүрээг тэлж, нийтлэлд тавигдах шаардлагыг нь улам бүр дэлхийн жишигт ойртуулж, тогтмолжуулах болно. Сэтгүүл нь зөвхөн их, дээд сургуулийн багш, эрдэмтэд, оюутнууд төдийгүй төрийн болон хувийн хэвшлийн мэргэжлийн байгууллагуудын судлаачдын бүтээлийг нийтлэхэд улам бүр анхаарч байна.

Сэтгүүлийн зорилгоо ч мөн өндөр түвшинд тавьж, Монголын эдийн засгийн судалгааны чанарыг дэлхийн түвшинд хүргэхийн төлөө ажиллах болно. Ойрын ирээдүйд тавьж байгаа бидний нэг зорилт бол Эдийн засгийн судалгааны ажлуудыг индексжүүлж, дэлхийн олон нийтийн хүртээл болоход нь дөхөм болдог REPEC (REsearch Papers in Economics, www.repec.org)-д бүртгэлтэй болох явдал юм.

Энэ удаагийн дугаарт макро эдийн засгийн сүүлийн үеийн загваруудын нэг болох динамик стохастик ерөнхий тэнцвэрийн загвар, өсөлтийн эх сурвалжийн шинжилгээ, хүн ам зүй болон цаг уурын өөрчлөлтийн өрхүүдийн хэрэглээнд үзүүлж буй нөлөөг Монголын хувьд судалсан гурван ажил нийтлэгдэж байна. Та бүхэн манай сэтгүүлийн веб хуудаснаас (www.econjournal.mn) эдгээр болон өмнөх дугааруудад нийтлэгдсэн судалгааны ажлуудыг авч үзэх боломжтой бөгөөд өөрсдийн судалгааны ажлаа бидэн рүү илгээж болно. Та бүхэн цаашид биднийг улам бүр дэмжин ажиллана гэдэгт гүнээ итгэж байна.

Редакцийн зөвлөл